



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 15


Улаанбаатар хот

┌ Аудитын ажил хуваарилж, гүйцэтгүүлэх ┐
журам батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.10, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аудитын ажил хуваарилж, гүйцэтгүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 80 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

АУДИТЫН АЖИЛ ХУВААРИЛЖ, ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний аудитын газар /ҮАГ/ Төрийн аудитын тухай хуулийн 18.5-д заасны дагуу санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын компанид хуваарилж, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, аудитын ажлын чанарыг баталгаажуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаалаар батлагдсан Ажлын хэсэг аудитын ажил хуваарилж, гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Ажлын хэсгийн үйл ажиллагаа

2.1. Гэрээгээр аудит хийх компанид аудитын ажил хуваарилах үйл ажиллагааг Ажлын хэсгийн дарга хариуцан зохион байгуулна.

2.2. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга аудитын компанийн аудит хийх чадавхийн шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах шаардлага, тэдгээрийг хангасныг нотлох баримтыг тусгасан баримт бичгийг бэлтгэж ажлын хэсгийн гишүүдэд урьдчилан хүргүүлсэн байна. Ингэхдээ Байгууллагын нууцын тухай хуулийг чанд баримтлан ажиллана.

2.3. Ажлын хэсэг нь ҮАГ-ын нэрийн өмнөөс аудит хийх аудитын компаниудын хүний нөөцийн бүрдүүлэлт, тэдгээрийн боловсролын байдал, ажлын туршлагын талаархи судалгаа, мэдээлэл, хөрөнгийн хариуцлага хүлээх чадвар, үйлчилгээний болон техник хэрэгслийн бололцоо чанарыг хэлэлцэн дүгнэлт гаргаж Монгол Улсын Ерөнхий Аудитор танилцуулна.

2.4. Ажлын хэсгийн гишүүд хуралдаанаараа энэ журмын 2.6-д заасныг үндэслэл болгон ил санал хураалтын журмаар аудитын ажлыг хуваарилах бөгөөд ингэхдээ аудит хийх объектийн байршил, санхүүжилтийг заавал харгалзан үзнэ.

2.5. Төсвийн үнэлгээ нь ойролцоо ажлыг компаниудад хуваарилахдаа олон төрлийн хувилбарыг дэвшүүлж түүнээс сонголт хийх зарчим баримтлана.

2.6. Ажлын хэсгийн хуралд бүх гишүүд оролцох бөгөөд гишүүдийн олонхийн буюу 66,33 хувиас дээш саналын дэмжлэг авсан аудитын компанид тухайн ажлыг хуваарилж, аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрх олгоно.

2.7. Энэ журмын 3.1.6-д заасан багцлан бэлтгэсэн аудитын ажлыг компаниудад хуваарилахад ажлын хэсгийн хуралдааны протокол хөтөлсөн байна.

2.8. Ажлын хэсгийн хуралдааны дүнг Ерөнхий аудитор танилцуулж түүний шийдвэрээр аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээг Санхүүгийн аудитын газрын захирал МУ-ын Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1, 343.2, 343.3-ыг баримтлан аудитын компанитай байгуулна.

Гурав. Ажлын хэсгийн эрх, үүрэг

3.1. Ажлын хэсэг нь гэрээгээр аудит хийх аудитын компанид ажил хуваарилахдаа дараах үүрэгтэй.

3.1.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг ажлын хэсгийн гишүүн бүр гаргах, мөн 9 дүгээр зүйлд заасан албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

3.1.2. Аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аудитын компаниудын шинэчилсэн жагсаалт, тухайн компанийн аудитын ажил гүйцэтгэх хүний нөөц, тэдгээрийн мэргэшлийн байдал, ажлын туршлага, хөрөнгийн хариуцлага хүлээх чадвар, үйлчилгээний болон техник хэрэгслийн бололцоо чанарын талаарх мэдээллийн санг Санхүүгийн аудитын газар үүсгэж байх бөгөөд энэ шинэчилсэн мэдээллийг ашиглана.

3.1.3. Аудитын ажлыг аудитын компанид хуваарилахдаа компанийн ажил гүйцэтгэх хүний нөөц, түүний мэргэшлийн байдал, ажлын туршлага, тухайн ажилд ямар хүний нөөцөөр оролцох, зэргийг гол үзүүлэлт болгож, хөрөнгийн хариуцлага хүлээх чадвар, үйлчилгээний болон техник хэрэгслийн бололцоо, чанар зэргийг туслах үзүүлэлт болгоно.

3.1.4. Гэрээгээр аудит хийх "Урилга" болон аудитын ажил хуваарилсан талаарх мэдээллийг ҮАГ-ын цахим хуудсанд байрлуулж олон нийтэд мэдээлнэ.

3.1.5. Тухайн байгууллагад хийгдэх аудитын ажлын хэмжээ, аудитын үйлчилгээний төлбөр төсөвт тусгагдсан эсэх мэдээллийг Санхүүгийн аудитын газраас ажлын хэсгийн дарга, гишүүд авсан байна.

3.1.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга аудитын ажлын төлбөрийн хэмжээ буюу санхүүжилт, объектийн байршил зэргийг харгалзан аудит хийх нийт ажлыг багцлан бэлтгэж ажлын хэсгийн даргаар хянуулж, зөвшөөрлийг авч, энэ журмын 3.1.3-т заасан үзүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг аудитын компани тус бүрээр гаргаж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулна.

3.2. Ажлын хэсэг нь гэрээгээр аудит хийх аудитын компанид ажил хуваарилахдаа дараах эрхтэй.

3.2.1. Аудитын компани ҮАГ-тай гэрээ байгуулан аудитын ажил гүйцэтгэж байхдаа сонирхлын зөрчил гаргаж байсан, нэгдмэл сонирхлыг үүсгэж байсан, татварын байгууллагад өр төлбөртэй, ёс зүйн болон хууль тогтоомжийн зөрчлийг удаа дараа гаргаж арга хэмжээ авагдаж байсан аудитын компанид ажил хуваарилахгүй байна.

3.2.2. Аудитын компани гэрээний үүрэг, ажлын даалгавар, аудитын чанарын шаардлагыг ханган биелүүлээгүй, аудитын багийн гишүүдийг ҮАГ-ын зөвшөөрөлгүй өөрчилсөн, сонирхлын зөрчил гаргасан тохиолдолд Санхүүгийн газрын захирал энэ тухай Ажлын хэсэгт танилцуулж гэрээг цуцална.

3.3. Аудитын компани аудитын ажил гүйцэтгэхдээ энэ журмын 3.2.1-д заасан зөрчил дутагдал гаргахгүй ажиллах "Батламж"-ийг МҮЕА-т гаргаж өгөх бөгөөд ажлын хэсгийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн Ерөнхий аудиторгоос ажил гүйцэтгэх

итгэмжлэлийн “Эрхийн бичиг”-ийг тухайн аудитын компанид олгоно. /Батламж, Эрхийн бичгийн загварыг хавсралт 2/

3.4. Ажлын хэсгийн гишүүд МУ-ын Ерөнхий Аудиторын 2003 оны 02 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөж ажиллана.

Дөрөв. Гэрээгээр аудит хийх аудитын компанид тавигдах шаардлага

4.1. Аудитын ажил гэрээгээр гүйцэтгэх аудитын компанид дараах шаардлага тавигдана:

4.1.2. Аудитыг гүйцэтгэхдээ Иргэний хууль, Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хууль болон Аудитын олон улсын стандарт, ҮАГ-ын Санхүүгийн аудитын гарын авлага, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журмыг баримтлах;

4.1.3. Аудит эхлэхээс өмнө аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг Санхүүгийн аудитын газрын захирлаар хянуулж, батлуулах;

4.1.4. Гэрээнд тусгагдсаны дагуу ҮАГ-тай тогтоосон хугацаанд уулзалт хийж аудитын явцыг мэдээлж, хэлэлцэж байх;

4.1.5. Аудитын компаниас шалгагдагч байгууллагатай хийх уулзалтад ҮАГ-ын төлөөлөгчийг оролцуулах;

4.1.6. Аудитын компани аудитын явцад ҮАГ-ын зүгээс хянаж шалгахад шаардлагатай ажлын баримт материалыг бэлэн байлгах;

4.1.7. Аудитын ажлын баримт материалыг Үндэсний архивын газрын даргын баталсан архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу архивын нэгж болгон ҮАГ-т хүлээлгэн өгөх;

4.1.8. Энэ журмын 3.1.1-д заасан мэдэгдлийг гаргах;

4.1.9. Татварын өр төлбөртэй эсэх талаарх татварын байгууллагын тодорхойлолтыг ажлын материалд хавсаргах;

4.1.10. Үндэсний Аудитын Газраас шаардлагатай гэж үзсэн бусад материал, мэдээлэл.

4.2. Аудитын компаниуд хамтран холбогдох хуулийн дагуу түншлэлийн гэрээ байгуулан ҮАГ-аас хуваарилан өгсөн аудитын ажлыг гүйцэтгэж болно.

Тав. Чанарын хяналт

5.1. Аудитын компаниудын гэрээгээр хийж буй аудитын явц болон гүйцэтгэлд хийх чанарын хяналтыг МУЕА-ын шийдвэрээр томилсон ажлын хэсэг, эсвэл ҮАГ-ын Чанарын баталгаажуулалтын зөвлөл болон Дотоод аудитор хэрэгжүүлнэ.

5.2. Аудитын эрсдэлийн үнэлгээ хийх, ҮАГ-ын оролцоог тодорхойлоходоо “ҮАГ-ын Санхүүгийн аудитын гарын авлага”-ын Хавсралт А-1-д үзүүлсэн “Санхүүгийн аудитын эрсдэлийн удирдлагын хяналтын хуудас”, энэ журмын 3 дугаар хавсралтад заасан “ҮАГ-ын оролцоог тодорхойлох хуудас”-ыг ашиглана.

5.3. Гэрээгээр аудит хийх ажил дууссаны дараа Санхүүгийн аудитын газрын захирал дор дурьдсан ажлыг хийж гүйцэтгэнэ:

5.3.1. Аудитын компани гэрээний дагуу хийсэн аудитын ажлаа сайтар хянасан эсэх, үүнд холбогдох бүх асуудлыг хамруулсан эсэх, тавьсан асуултуудад бүрэн хариулт өгч чадсан эсэх, аудитын дүгнэлтийг дэмжиж буй эсэхийг нягтлах, эрсдэл өндөртэй аудитын хувьд, төлөвлөлтийн явцад ноцтой гэж тодорхойлсон эрсдэлтэй асуудлын талаар аудитын компанийн хийсэн ажлын чанар, үр дүнг үнэлэх;

5.3.2. Санхүүгийн тайлангийн ерөнхий хяналт, дотоод хяналтын талаарх тайланг аудитын компани сайтар хянасан эсэхийг нягтлах;

5.3.3. Аудитын компанийн илрүүлсэн зөрчил, хийсэн ажиглалтуудын талаарх мэдээллийг нягтлах, шалгагдагч байгууллагад танилцуулах, асуудлыг аудитын компанитай хэлэлцэх, санал боловсруулах;

5.3.4. Шалгагдагч байгууллагад аудитын дүнг танилцуулах төгсгөлийн уулзалтад оролцох;

5.3.5. Аудитын компанийн менежментийн захидлыг хянаж, шалгагдагч байгууллагын удирдлагад илгээх;

5.3.6. Менежментийн захидлын хариуг аудитын компанид танилцуулж, санал дүгнэлтийг нь сонсох;

5.3.7. Аудитын компанийн төлөөлөгчтэй уулзаж, аудитын дүн, үр өгөөж, үр дагаврыг хэлэлцэх.

5.4. Санхүүгийн аудитын газрын захирал энэ журмын 5.3-т заасан ажлыг өөрийн итгэмжлэгдсэн Үндэсний аудитын газрын албан тушаалтнаар гүйцэтгүүлж болох бөгөөд энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа. Гэрээг дүгнэх, хариуцлага тооцох

6.1. Санхүүгийн аудитын газрын захирал аудитын компанийн ажлын гүйцэтгэл, гэрээний биелэлтийг энэ журмын 3-т заасан шаардлагыг харгалзан дүгнэнэ. Ингэхдээ аудитын компани, шалгагдагч байгууллагын саналыг авч болно.

6.2. Санхүүгийн аудитын газрын захирал гэрээний биелэлтийн дүнг МУ-ын Ерөнхий аудиторт танилцуулна.

6.3. Гэрээний үүргээ биелүүлсэн гэж үзсэн аудитын компанид аудитын үйлчилгээний төлбөрийн үлдэх хэсгийг шилжүүлэх мэдэгдлийг шалгагдагч байгууллагын удирдлагад албан бичгээр хүргүүлнэ.

6.4. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн аудитын компанийн авбал зохих аудитын үйлчилгээний төлбөрөөс гэрээнд заасны дагуу хасах, эсхүл гэрээг цуцалж, энэ талаар шалгагдагч байгууллагад Санхүүгийн газрын захирал албан бичгээр мэдэгдэнэ.

6.5. Аудит хийлгэсэн ажлын төлбөрийг гэрээнд зааснаар шийдвэрлэнэ.

6.6. Гэрээний үүргээ биелүүлээгүй, мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан аудитын компанийн гэрээг цуцлах, давтан зөрчил гаргасан тохиолдолд дахин УАГ-ын нэрийн өмнөөс хийх аудитад оролцуулахгүй байх шийдвэрийг Санхүүгийн газрын захирлын саналыг үндэслэж, Монгол Улсын Ерөнхий аудитор гаргана.

6.7. Гэрээгээр аудит хийх ажлын талаар гарсан аливаа маргааныг Ажлын хэсэг, Санхүүгийн аудитын газар, шалгагдагч байгууллага, аудитын компанийн эрх бүхий төлөөлөгчидтэй хамтран хэлэлцэж, зохих журмын дагуу шийдвэрлэж байх бөгөөд хэрэв харилцан тохиролцож чадаагүй бол шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

--- oOo ---